



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.12.02 № 05/16402

танай -ны № -т

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ  
ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА  
Д.БАЯНДҮҮРЭН ТАНАА

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлэг хянасан тухай

Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн хүний нөөц, дотоод хяналт хариуцсан ахлах референтээр томилогдохоор нэр дэвшсэн Дашдаваагийн Мөнгөндуулга, Мэдээлэл судалгаа, сургалтын төвийн нийслэл хариуцсан референтээр томилогдохоор нэр дэвшсэн Батдэлгэрийн Батхишиг, Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн орон нутаг хариуцсан референтээр томилогдохоор нэр дэвшсэн Батцэндийн Нямсүрэн, Хуулийн хэлтсийн өргөдөл гомдол дотоод ажил хариуцсан референтээр томилогдохоор нэр дэвшсэн Шархүүгийн Эрдэнэбат нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Т.ЭНХБОЛД



142203021352